

БАРУУН-УРТ СУМЫН 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 80 бичиг явж, 118 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-17, хугацаандаа явсан-4, хугацаа болоогүй-3 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тайлант сарын байдлаар Засаг даргаас 52 захирамж гаргасан.Үүнд:

“А” захирамж-41, “Б” захирамж-11,

Тамгын газрын даргаас “А” тушаал-9, “Б” тушаал- 36 тус тус гарсан байна.

“Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 16 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 350 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний оператораас 296 иргэнд лавлагаа үйлчилээ гаргаж үйлчилсэн. Төлбөртэй үйлчилгээ-37, төлбөргүй-259 үйлчилгээ байна.

Тамгын газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор орон нутгийн BBS тв, Сүхбаатарын өнгө сонин, Sb ingo сайт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 40 удаа мэдээлэл нийтэлсэн.

Багийн Засаг дарга нар айл өрхөөр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Алдарт эхийн одонгийн болзол хангасан эхчүүдийн материалыг хүлээн авч байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:2023 оны эрх зүйн ажлын төлөвлөгөөг боловсруулан, Тамгын газрын даргаар батлуулан ажиллалаа.Мөн эрх зүйн хөтөчөөр гурван албан хаагчийг бэлтгэхээр аймгийн Тамгын газрын хууль эрх зүйн хэлтэстэй гэрээ байгууллаа. Сумын Засаг даргын 52 захирамж, Тамгын газрын даргын 45 тушаалын эрх зүйн үндэслэлийг хяналаа.

Тайлант сард нийт 97 шийдвэрийн төсөл хянаж, эрх зүйн зөрчилгүй шийдвэр гаргаж хэвшсэн. Тамгын газрын 2 дугаар сарын тайланг гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-т хугацаанд нь хүргүүллээ.

Байгууллагын дотоод зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнд тус Тамгын газрын 47 албан хаагч хамрагдсан бөгөөд 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөө, баримтлах бодлого чиглэлээ тодорхойлон, санал солилцлоо.

Харъяа төсөвт байгууллагуудын зөвлөгөөнийг тус Тамгын газраас санаачлан зохион байгууллаа. Тус Зөвлөгөөнд оролцсон удирдлагуудад "Зөв хэвшил-зөв амьдрал" хөтөлбөрийг танилцуулан, хамтран ажиллах санал солилцсон.

Баруу-Урт сумын хэмжээний сэтгэл зүйч мэргэжилтэй иргэдийн судалгааг гарган уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 7 иргэн оролцсон бөгөөд арга хэмжээнд оролцсон иргэдэд “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг танилцуулан хамтран ажиллах санал солилцлоо.

Сургууль, цэцэрлэгийн сарын ажлын тайланг хэлэлцэн үнэлгээ өгч ажиллалаа. Тайлант сард 15 байгууллагын тайлан хэлэлцсэн. Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөөг 6 бүлэг 15 заалтаар гарган Тамгын газрын даргаар батлуулан ажиллалаа. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан сумын ИТХ-д танилцуулан батлуулан хяналтад авч ажиллалаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах 140.000.000 төгрөгийг мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн.

Багийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Төрсний бүртгэл-44, эцэг эх тогтоосны бүртгэл-2, нэр өөрчилсний бүртгэл-1, Иргэний үнэмлэхний хугацаа дуусч авсан-65, шинээр олгосон иргэний үнэмлэх-39, Аймаг, хотоос шилжин ирсэн-21, хот доторх шилжилт хөдөлгөөн-50, сум дүүрэгт шилжин ирсэн-18, баг хооронд шилжсэн-46, гэрлэлт цуцлалт-4, Үрчлэлт-1, овог нэр өөрчилсөн-1, нас баралт-16 тус тус бүртгэн үйлчилсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/674, сумын Засаг даргын А/01 захирамжаар шинэчилсэн тоо бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 04-нөөс 01 дүгээр сарын 20 хугацаанд зохион байгуулж ажиллалаа. Цэргийн тоо бүртгэлийг 9 багийн групп хуудас болон ИҮТ-ийн ЛЕД дэлгэцээр давтамжтайгаар зар мэдээллийг байршуулж ажилласан. 2023 цэргийн тоо бүртгэлийн мэдээгээр:

Бэлтгэл офицер-33, бэлтгэл ахлагч-21, 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн-1445, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн-2270, дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан-137, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан-77, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд хамрагдаагүй буюу завсардсан-1269, төрийн цэргийн байгууллагын албан хаагч-159, цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд-238, орон нутгийн цэргийн байгууллагын албан хаагчид-23, идэрчүүд-354, 2023 оны цэргийн шинэчилсэн бүртгэлийн хувь-73.1%, цэргийн бүртгэлээр цэргийн үнэмлэх гээгдүүлсэн, шинээр 18 нас хүрч буй 87 иргэнд үүрэгтний үнэмлэхийг шинээр олгож бүртгэлээ.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд овог нэрээ солиулсан 14 иргэний материалыг нэгтгэн мэдээллийг аймгийн статистикийн хэлтэст хүргүүллээ. ХАӨМСан, Улсын бүртгэлээс ирүүлсэн зөрүүтэй мэдээллийн тодруулгын талаар хийсэн ажлын тайлан, тоон мэдээллийг гарган Статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Мөн аймгийн Улсын бүртгэлийн газраас ирсэн 1544 иргэний хаягийн мэдээллийн тодруулгыг нэгтгэн гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.

Санхүү, төрийн сангийн чиглэлээр: Малын тоо толгойн татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өвс тэжээлийн дэмжлэгийг 2021, 2022 оны татвараа төлсөн малчин иргэнд олгосон. 2 сарын өссөн дүнгээр 8.0 сая төгрөг төвлөрөөд байна. 2-р сарын байдлаар 1,447.6 сая төгрөгийн /441 ш/ гүйлгээг хийж баталгаажуулсан.

Төсөвт байгууллага, ОНӨААТҮГ-уудад 247,840.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Сумын татварын болон татварын бус орлого 248,275.0 мянган төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөө 42 хувьтай байна. 2-р сарын татварын орлогын бүрдүүлэлт 248,275.4 мянган төгрөг орж, орлогын төлөвлөгөө 42 хувьтай байна.

Өдөр тутмын гүйлгээ Finance.gov.mn системийг ашиглан цахимаар хийж байгаатай холбоотойгоор хяналтыг хийж, арга зүйн зөвлөгөөн өгч ажиллаж байна. Аж ахуй нэгжийн тайлан илгээлт нь 65 хувьтай байна. 8 байгууллага дарга, удирдлагуудад нь үүрэг чиглэл өгч, төсөвт 101.0 сая төгрөгийг тусгаад байна.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж төлөвлөх ажлын хэсгийг А/06 тоот захирамжаар байгуулан ажилласан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван тавдугаар хурлын 15/12 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн жагсаалтыг 3/1254 тоот, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 3/3 тоот албан бичгээр орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ сайт болон зууны мэдээ сонинд Нийтийн эзэмшлийн орон сууцнуудийн дээвэр засвар / 7 дугаар баг, 27 в байр, одкон хотхон 1, 2 дугаар байр / ажлын урилгыг мэдээлж тус тендер 02 дугаар сарын 03-ний өдөр нээж тендерт 7 компани оролцож материал үнэлэх шатандаа явагдаж байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ухаалаг төхөөрөмж суурилуулж нийлүүлэх ажлын тендерийн үнэлгээний хороо байгуулах ажлын хэсгийг А/42 тоот захирамжаар байгуулаад байна.

2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт, гүйцэтгэлийг удирдлага мэдээллийн системд шивж, 2023 оны төлөвлөгөөг байршуулсан. 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн тайланг слайдаар бэлтгэн байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн хөгжлийн сан гэсэн пэйж хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн 2023 оны төсвийн ил тод байдал зурагт хэвлэмэл хуудасыг төсөв төрийн сангийн мэргэжилтэнээр бэлтгүүлж вэб сайт болон пэйж хуудсаар мэдээлсэн.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтад хамрагдах 4 албан хаагчийн нэрсийн жагсаалтыг 3/31 тоот албан бичгээр орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Шалгалтад 3 албан хаагч тэнцсэн. Харьяа төсөвт 8 байгууллагын 10 албан хаагч тэнцсэн.

Худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байх зарчмыг баримтлан 2023 оны төлөвлөгөө хэрэгжилтийг shilendans.gov.mn, сайтад байршуулсан

Ухаалаг төхөөрөмж суурилуулж нийлүүлэх ажлын үнэлгээний хороог сумын Засаг даргын А/42 тоот захирамжаар байгуулж ажилласан Орон нутгийн хөгжлийн сан болон хоршоо хөгжүүлэх сангийн анхан шатны баримтыг 2 дугаар сарын 13 нд төрийн аудитын газарт хүргүүлсэн.

2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн зарцуулалтын мэдээг албан бичиг болон цахим хаягаар хөрөнгө оруулалт төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн ажилласан. 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн тайланг байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн хөгжлийн сан гэсэн пэйж хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: JCI байгууллагаас Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд амьдрал б+элэг төслийн баг элэгээ хайрладаг иргэдэд зориулж элэгний өвчлөл, эрт илрүүлэх арга зам, тэмцэх арга замын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 9 багийн 80 гаруй иргэн хамрагдаж, мэдээлэл авсан.

Аймгийн улаан загалмайн хорооноос малчин өрх Э.Мөнхжаргалын 370.000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламж үзүүлсэн.

2 дугаар багийн иргэн Ж.Батбаярмаа "ОД" сувилахуйн төвөө албан ёсоор нээж иргэдэд үйлчилж эхэллээ. Тус төвийн нээлтэд оролцож цаашид багийн иргэдийг хөнгөлөлттэй хамруулах талаар ярилцаж хамтран ажиллахаар боллоо.

Сар шинийн баярыг тохиолдуулан УИХ гишүүн Б. Батсуурь, Н.Ганибал нар 2 дугаар сарын 19-ны өдөр Баруун-Урт сумын ахмадуудыг хүлээн авч битүүллээ. Тус битүүлэгт 2 дугаар багийн 35 ахмадыг хамруулж ажиллалаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан 90-ээш дээш настай ахмад настанд аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулан өглөө.

Хүүхдийн хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс хүүхдүүдийнхээ чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, тоглох, сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Янзган хүрээ" хүүхдийн өрөөг тохижуулан ажиллаж байна. Энэ сард хүүхдийн хөгжлийн буданг тохижуулах зорилгоор "НЭГ АЛБАН ХААГЧ -НЭГ ТОГЛООМ" аяныг өрнүүлээд байна.

Төлөөлөгч Ч.Дорждэрэмийн дэмжлэгээр 4 дүгээр багийн 20 өрхөд 100 шуудай нүүрсний дэмжлэг, багийн иргэн З.Эрхэмбаярын санаачлагаар 5 өрхөд 5 тн түлээ нүүрсний дэмжлэгийг тус тус үзүүлсэн.

6-р багаас сонгогдсон аймаг, сумын иргэдийн төлөөлөгч нар хамтран багийн зорилтот бүлгийн 100 өрхөд түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн. Дэмжлэгт 4000000 зарцуулсан. Төлөөлөгч Ө.Эрдэнэбат багийн ахмад настнаар орж санал хүсэлтийг нь сонсч, хүндэтгэл үзүүлсэн. Мөн өрх толгойлсон болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүллээ.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын талаарх мэдлэг ойголт өгөх сургалтад 10 албан хаагч хамрагдан сертфикат авсан.

“Ахмадаа сонсоё” арга хэмжээг сумын ахмадын биеийн байдал болон амьдралын нөхцөлтэй танилцах, тэдний санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх, уламжлах, төрийн үйлчилгээг сурталчилан таниулах, тэдэнд хүрч үйлчлэх зорилгоор зохион байгуулж 70 ахмадын гэрээр айлчилсан. Тус арга хэмжээнд 336000 төгрөг зарцуулсан.

Багийн Засаг дарга нараас иргэдийн санал, хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд 650000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

Ахмадын хороотой хамтран 9 багийн ахмадуудын дунд 270 ахмадыг оролцуулсан найрал дууны тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Монголын ахмадын хорооноос гаргадаг "Ахмад үе" сониныг 43 ахмад захиалан уншиж байна. Аймгийн ахмадын хорооноос зохион байгуулсан 2 өдрийн сургалтад ахмадын хорооны дарга хамрагдсан.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтын төсвөөс нийт 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр Энэрэлт ачтан Өрхийн эрүүл мэндийн төвд татлагын ор, Энхлэн ачтан Өрхийн эрүүл мэндийн төвд хаш чулуун ор тус тус олгосон.

Эрт илрүүлэг үзлэгт давхардсан тоогоор нийт 5253 хүн хамрагдсан үүнд: Артерын даралт-1671, чихрийн шижин -1481, хөхний хавдрын үзлэг-1215, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг-211 0-17 насны хүүхдийн эрт илгүүлэг үзлэгт 675 хүүхэд хамрагдсан.

Сэргээн засах болон уламжлалт 17 нэр төрлийн эмчилгээнд өвчтөний онош, зовиурыг харгалзан нийт 270 хүнийг эмчилсэн байна. Мөн ОНХС-ийн санхүүжилтээр 20,0 сая төгрөгийн сэргээн засах эмчилгээний хаш чулуун ор, татлагын ор зэрэг тонгог төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.

Элэг бүтэн Сүхбаатар, гепатитгүй Монгол төслийн хүрээнд иргэдэд үйлчлэх төвийн байранд 66 иргэнийг дуудаж түргэвчилсэн оношлуураар элэгний В.С вирусн шинжилгээнд хамруулсан.

Ногоон байгууламжийн чиглэлээр: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 3/09 тоот тогтоолыг үндэслэн золбин нохой устгах ажлыг зохион байгуулан ажилласан.

Устгалын ажлыг 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт зохион байгуулдаг. Нийт 83 ширхэг золбин нохойг устгасан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/537 дугаар “Ногоон байгууламжийн хамгаалалтыг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх” захирамжийн дагуу өдөр бүр хотын төвөөс мал гаргах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Энэ сард давхардсан тоогоор 50 тооны үхэр байгууллагын мал түр хаших хашаанд хашин, холбогдох байгууллагаар эзэн холбогдогчийг тодорхойлуулан, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авсан. Нийт 340 тооны малыг нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон бүсээс хөөж гаргасан. Үүнд 220 тооны үхэр, 120 тооны адуу байна.

Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайд эзэнгүй үүссэн малын сэг зэмийн устгалын ажлыг Сүхбаатар Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар хамтран

зохион байгуулан ажиллаж байна. Нийт 7 тонн сэг зэмийг зөөж тээвэрлэн, төвлөрсөн хог хаягдлын цэгт булшилсан болно.

Баруун-Урт сумын хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний дагуу 6, 7, 9 дүгээр цэцэрлэгийн багш, ажилтанд хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох сургалтыг зохион байгуулан ажилласан болно. Нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд 50 багш ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах мэдээллийг өгч ажилласан.

Баруун-Урт суманд үйл ажиллагаагаа явуулж буй мах боловсруулах үйлдвэр, хүнсний дэлгүүрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Түүврийн аргаар 21 аж ахуй нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн болно.

Хяналт шалгалтын явцад илрүүлсэн хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүнийг дэлгүүрийн лангуунаас буулгуулан холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэн ажилласан.

Газар зохион байгуулалт, хот тохижилтын чиглэлээр: Баруун-Урт сумын засаг даргын тамгын газрын захирагчийн албанаас орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар аймгийн 3-р багийн хиймэл нуурийн тохижилт, ус зайлуултын ажлын 7.0 сая төгрөгийн гэрээ, 7 дугаар багийн худалдааны гудамжны тохижилтын ажил төсөв 5 сая, 4,6 дугаар багийн голын явган замын тохижилт төсөв 1.5 сая, 9 дүгээр багийн гадна камержуулалтын ажил төсөв 7.0 сая төгрөгийн гэрээнүүдийг зураг төслийн Батсүмбэрэл ХХК байгуулан ажлын даалгавар боловсруулж магадлалаар оруулж батлуулан тендер зарлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн 1,3 дугаар багийн тоглоомын талбайн засвар үйлчилгээний ажлын зураг төсвийг хийж гүйцэтгэж байна. Баруун-Урт сумын 2 дугаар баг Саруул хотхоны гадна тохижилтын ажлыг тус онд батлагдсан 60.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг ММ архитектур ХХКомпанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Цагаан сар нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу аж ахуй нэгж байгууллагуудын үйлчилгээний чанар стандартад хяналт тавих, байгууллагын гадна дотно тохижилт үйлчилгээ, мянган сэтгэл сайн үйлсийн аяныг сурталчилах зорилгоор 21 аж ахуй нэгжээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 02 дугаар сарын 13-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. Хугацаа чанад дууссан 250,0 мянган төгрөгний бүтээгдэхүүнийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх BEST хөтөлбөрийн Хэнтий аймаг дахь салбарын зохицуулагч, бизнес зөвлөх Н.Болорчимэгтэй хамтран "БИЗНЕС ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ" аргазүйн сургалтыг зохион байгуулж шинээр жижиг, дунд бизнес эрхлэх хүсэл сонирхолтой, бизнес эрхэлдэг 19 иргэнийг хамрууллаа. Сургалтаар бизнес төсөл хэрхэн боловсруулах арга зүйн сургалт, зөвлөгөө өгөхөөс гадна зээл, санхүүжилтийн боловсрол, бизнесээ хэрхэн удирдах, зохион байгуулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/615 дугаар захирамжаар” Аймгийн аварга малчин” шалгаруулах журмын дагуу тус сумын 8-р багийн малчин О.Азжаргал, Ш.Лутбаяр, М.Цогтбаатар, 4-р багийн малчин Л.Ганбат нарыг тодорхойлж материалыг хүргүүлж шалгарсан малчдад шагналыг хүргүүлсэн.

Сумын аварга малчин, сумын тэргүүний фермер, аварга саальчин, аварга тариаланч шалгаруулах журмын дагуу сумын аварга малчнаар 16 малчин, 1 фермерийн материалыг хүлээн авч Засаг даргын зөвлөлд танилцуулан 14 аварга малчин, 1 аварга фермерийг шалгаруулж шагнал гардуулан арга хэмжээг зохион байгуулсан.

Гамшгийн нөөц сангаас 10,000,000 төгрөг, засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтээс 10,000,000 төгрөгийн санхүүжилтийг гаргаж 1250 шуудай хивэгийг Дорнод гурил ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч татан авалт хийсэн. Сумын аюулгүй нөөцөд байсан нийт 4000 боодол өвс, 1590 шуудай хивэгээс нийт 997 малчин өрхөд олгохоос 775 малчин өрхөд 3318 боодол өвс, 1527 шуудай хивэгийг малчдад өвс тэжээлийн дэмжлэг үзүүлж ажилласан.

Мал аж ахуйн төлөвлөлт бүртгэлийг программын тулгалт нийт 1674 өрхийн материалд тулгалт хийхээс 400 өрх буюу 23 хувьтай байна.

Аймгийн Онцгой байдлын газартай хамтран галын аюулгүй байдлыг хянаж шалгах ажлын хэсэгт орж ажиллаж байна. Тус сумын 5,9 дүгээр багт 02-р сарын 14,15-ны өдрүүдэд 2 удаагийн объектийн гал түймэр гарч иргэд эд хөрөнгөөрөө хохирсон мэдээлэлтэй байна.

Боловсролын чиглэлээр:2023 оны Аймгийн ИТХ-аас "Хүүхдийн хөгжил хамгаалал"-ын жил болгон зарласан. Аймгийн Цагдаагийн байгууллага, Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан "Анзаар" аяны нээлтэд оролцон Ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн сурагчдад хорт зуршлын талаар ойлголт, мэдлэг олгох ажлыг хамтран зохион байгууллаа. Сургалтад Ерөнхий боловсролын 4-н сургуулийн 128 багш, ахлах ангийн 480 хүүхэд хамрагдаж мэдээлэл авсан.

2023 оны 2 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд 38 кейс ирж үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй 6 кейс, гэр бүлийн хүчирхийллийн 32 кейсийг хяналтдаа авч хариу арга хэмжээг үзүүлэн ажиллаж байна. Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран кейс хэлэлцүүлгийг зохион байгуулж 2023 онд хамтран ажиллах ажлын чиглэлээ авч ажиллаж байна.

Ерөнхий боловсролын 1 дүгээр бүрэн дунд сургууль нь 2022 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 17 сая төгрөгөөр Дижитал эрин үед сургалтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, тасралтгүй байдлыг хангах зорилго бүхий "Хосолсон сургалтын танхим - Газарзүйн кабинет"-ыг байгуулж нээлтээ хийлээ.

Сумын Монгол хэл бичгийн орон тооны бус зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг 15 ажил арга хэмжээ зохион байгуулахаар тусган батлууллаа.Мөн соёл урлагийн чиглэлээр 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган батлууллаа.

2 дугаар сард "Монгол хүн- Монгол хүүхэд" сарын хүрээнд Уламжлалт сар шинийн баярыг угтан "Амар байна уу" нэвтрүүлгийг сумын харьяаны сургууль, цэцэрлэгийн багш ажилтан албан хаагч хүүхэд багачуудтай хамтран зохион байгуулж орон нутгийн телевизээр олон нийтэд сурталчлан таниуллаа.

Амар байна уу байгууллагын сар шинийн нэвтрүүлэгийг мэргэжилтнүүдээс санаачлан зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Тамгын газрын 47 албан хаагч, 23 байгууллагын ахмад настнууд, харъяа төсөвт байгууллагууд удирдлагууд оролцож 5 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулж, үндэсний өв соёлоо сурталчилан, түгээн дэлгэрүүлж ажилласан. Мөн арга хэмжээнд оролцсон байгууллагын ахмад настнууд болон харъяа төсөвт байгууллагууд удирдлагуудад сар шинийн мэнд хүргэж хүндэтгэл үзүүллээ.

Тус сумын 8 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийн ая тухтай орчинд сурч хөгжих, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэхэд 500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, орчны бохирдол үүсэхээс сэргийлэх, экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая аянг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулан ажилласан болно.

Тус аянд Баруун-Урт суманд үйл ажиллагаагаа явуулдаг нийт 8 байгууллага зохион байгуулсан ажлын тайлангаа хүргүүлсэн болно. Үүнээс 2 сургууль, 6 цэцэрлэг идэвх санаачилгатай оролцсон.

Баруун-Урт сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан Монгол Улсын гарамгай начин Л.Дашдаваа агсаны нэрэмжит “Зодогтой багачууд” бөхийн тэмцээн зохион байгуулагдаж Баруун-Урт сумын хүүхдийн 11 цэцэрлэгийн, 64 хүүхэд амжилттай оролцсон.

11 дүгээр цэцэрлэг: 151 хүүхдэд энгийн болон хуванцар, аюултай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын тэмдэглэгээтэй хогийн саванд хийх ёстой гэсэн анхан шатны мэдлэгийг өгч ажилласан. Цэцэрлэгийн хүүхдийн өдөр тутмын сургалт үйл ажиллагаа, ариун цэвэр сахих үед гардаг хогны ихэнх хувь нь цаасан хог хаягдал байдаг учир цаас хаях зориулалтын тэмдэглэгээтэй саванд хийж хэвшиж байна. Цэцэрлэгийн хүүхдийн өдөр тутмын сургалт үйл ажиллагаа, ариун цэвэр сахих үед гардаг хогны ихэнх хувь нь цаасан хог хаягдал байдаг учир цаас хаях зориулалтын тэмдэглэгээтэй саванд хийж



хэвшиж байна.

“Аюулыг авдарлая” уриан дор давхардсан тоогоор нийт 276 эцэг эх, 23 багш ажилтанд аюултай хог хаягдлын хор уршигийг таниулах тараах материал боловсруулан хүргэж ажиллаа.

Үүний үр дүнд багш ажилтан, эцэг эхчүүд гэрийн нөхцөлд ашигласан зай, хугацаа




дууссан эм зэргийг шууд байгальд хаяхгүйгээр тусгай шилэн саванд цуглуулж эхэлсэн. Мөн 5 бүлгийн дунд ашигласан зай, хугацаа дууссан эмийг цуглуулах 10 хоногийн аян өрнүүлж нийт 231 капсул антибиотик, тариа, 224 ширхэг зайг цуглуулж 179200000 литр ус\ байгаль дэлхийгээ бохирдлоос хамгаалах боломжийг бүрдүүлсэн.

3 дугаар цэцэрлэг: Хүүхдэд аюултай хог хаягдал /электрон төхөөрөмжийн зай, хугацаа нь дууссан эм антибиотик сэдвээр 7 бүлгийн туслах багш нар сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж 180 хүүхэд хамрагдлаа.



Гэр бүлийн орчинд хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх цахим зөвлөгөө зөвлөмж, зурагт хуудас, санамж 46 удаа, зөвлөгөө гарын авлага материал 120 ш тус тус түгээж ажилласан.




Цэцэрлэгийн хэмжээнд “Хариуцлагатай даалгавар” аяныг өрнүүлж, хаягдал зай, хугацаа нь дууссан эм цуглуулах цэгийг цэцэрлэгийн угтах хэсэгт нээснээр 1700ш хуруун зай, 65ш товчин зай, 49 нэр төрлийн нэр төрлийн эмийг цуглуулж, аюултай хог хаягдлыг ангилан ялгах талаарх мэдээллийг хүүхэд, эцэг эх олон нийтэд сурталчилсан.



6 дугаар цэцэрлэг: Баруун-урт сумын Тамгын газраас зохион явуулж буй “Аюулыг авдарлая” аяны удирдамжийн дагуу байгууллагын багш ажилчид, хүүхэд, эцэг эхэд аюултай хог хаягдлын хүрээнд гэртээ ашиглахгүй болсон бүх төрлийн хуруун зай, товчин зай, хугацаа нь дууссан эм зэргийг цуглуулах “Аюулыг авдарлая” буланг цэцэрлэгийн төв хаалганд байршуулан ажилласан болно.




Байгууллагын болон бүлгүүдийн нээлттэй групп хаягт Аюултай хог хаягдлын хор уршгийн тухай зөвлөгөө зөвлөмж, контент зэргийг байршуулан эцэг эх, олон нийтэд мэдээллийг хүргэн ажилласан.




4 дүгээр цэцэрлэг: Эм бол хор, товчин зай сургалт үйл ажиллагааг 5 бүлгийн 88 хүүхдэд зохион явуулсан. Аюулыг авдарлая хүүхдийн эрүүл мэнд болон байгаль орчинд хэрхэн нөлөөлөх 2 төрлийн контент бэлтгэж бүлгийн групп, сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 4-р цэцэрлэгийн хаягаар хүргэв.



Нэг зай 1м² газар, 8000л ус аян өрнүүлж бүлэг бүр товчин болон хуруу зай хийх хогийн сав бэлтгэж хэрэглээ дууссан зайг хураан авлаа.



Тун ихэдвэл хор үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхэд багачуудад эмийн хор нөлөө, хэрэглээг сурталчлах, гэр бүлийн өрхийн эмийн санг цэцгэлж хугацаа дууссан эмэнд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.




9 дүгээр цэцэрлэг: Аюултай хог хаягдлыг эцэг эх олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор самбар байршуулан, зохион байгуулах ажлын чиглэл, санамж уриалгыг булангаар дамжуулан хүргэж ажиллаа.



Мөн аяны эхэнд багш ажилчид болон “Ахлах”, “Бэлтгэл” бүлгийн хүүхдүүдээс хог хаягдлыг ангилан ялгах мэдлэг зөв дадал хэвшлийн талаар тандалт судалгаа хийсэн. Судалгаанаас дүгнэхэд хогоо ялган ангилах хэвшил хангалтгүй, аюултай хог хаягдлын талаарх мэдлэг дутмаг байсан тул эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шат дараалсан

сургалтуудыг холбогдох байгууллага болон өөрсдийн нөөц боломж дээр тулгуурлан удирдлага, багш нарын баг 3 удаагийн сургалтыг зохион байгуулж 31 багш ажилчид 189 хүүхэд хамрагдсан байна.



Удирдамжинд заасны дагуу “Сүхбаатар тохижилт үйлчилгээний газрын сургалт хариуцсан ажилтан Ц.Болортуяатай хамтран “ АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ “ сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 28 багш ажилчдыг хамруулсан.

Сургалтын мөрөөр хүүхдийн насны онцлогт тохируулан бүлгийн багш нар бүлэг тус бүртээ сургалт үйл ажиллагаа, туслах багш нар хөгжөөн баясгах ажлыг зохион байгуулж хог хаягдлыг ангилан хаях талаарх мэдлэгийг дамжуулан цаашид дадал хэвшил болохуйц ажлуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тусган ажилласан. Бүлгийн багш нар хаягдал материал ашиглан хогийн сав, номын төвдөө бяцхан ном хийж сургалтандаа ашиглан мэдлэгийг бататгасан. Сургалтын үр дүнд анги бүр хогоо ангилан ялгах хогийн савтай болж хүүхдүүд хогоо ангилж хаях чадварт суралцлаа.


Ангидаа ангилан ялгах хогийн савтай болсноор сургалтанд хамрагдсан 137 хүүхдүүдийн 81% нь хаягдал цаас, гялгар уут хоолны үлдэгдлээ ангилан хаяж сурсан үр дүнтэй.

Аймгийн эрүүл мэндийн газрын эм зүйч А.Нямсүрэнтэй хамтран “ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ” сэдэвт сургалтыг байгууллагын 29 багш ажилчдыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр багш ажилчид гэрийн эмийн сангаа авчирч эмийн санд тавигдах шаардлагын дагуу цэгцэлж хугацаа дууссан болон хадгалалтын горим алдагдсан 12 нэр төрлийн 78 эмүүдийг устгалд оруулсан. Дээрх сургалтын үр дүнд эмийг зөв хадгалах, хугацааг харах, эмийг зөв талаас нь эхэлж задалж хэрэглэх, ангилах ялгах, бага насны хүүхдээс хол байлгах, зөв уух талаар мэдлэгтэй болж эрүүл мэндийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийсэн.

Бүлгийн багш нар бүлэг тус бүртээ “Хог ангилан ялгах чадварт суралцах нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



Хог хаягдал, эмийн зохистой хэрэглээний талаар бүлгийн багш нар цахим контент бэлтгэн ангийн дотоод группээр дамжуулан хүүхэд, эцэг эх, асран хамгаалалч нарт хүргэн ажиллаа. Нийт 7 контент бэлтгэн хүргэсэн. Хүүхдэд сонирхолтой хэлбэрээр богино хэмжээний цахим контент бэлтгэн хүргэснээр хүүхдэд сонирхолтой байж, хүүхдийн мэдлэгийн хүрээ тэлж хүлээн авах, ойлгох чадварт ахиц гарсан.



Дахин ашиглах боломжгүй аюултай хог хаягдал зайг хүүхэд бүр авчирч цэцэрлэгийн явууллын хайрцагт хийж хийсэн хүүхэд бүрт витамин өгч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий дүрийн тоглолтыг Туслах багш нар хүүхдүүдэд тоглож мэдлэг түгээлээ. Орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж Хариуцлагатай жижүүр аяныг өрнүүлж өдөр бүр байгууллагын гаднах хогийг цэвэрлэж хогийн цэгийн хогны савыг ариутгалаа.



Хаягдал зай, эмийг стандартын дагуу хаях хадгалах ажлын хүрээнд эцэг эх асран хамгаалагчдаас зай, эм цуглаах аянд нэгдэж оролцсон эцэг эх хүүхдүүдийг витаминжуулж, урамшуулж зайны хор уршгийн талаар мэдээлэл бүхий цаасан гарын авлага боловсруулан түгээсэн. Мөн албан байгууллага аж ахуй нэгж, айл өрхүүдэд хог хаягдлын талаар мэдээлэл түгээн, хогоо ангилан ялгаж хаях талаар уриалан, аюултай хог хаягдлын хор уршгийн мэдээлэлүүдийг хүргэж ажиллаа. Энэхүү аяны хүрээнд хуруу зай 382 ширхэг, товчин зай 5 ширхэг, хугацаа дууссан 32 эмийг зориулалтын хайрцагт хийсэн.

1 дүгээр цэцэрлэг: Аяны хүрээнд шалгуур үзүүлэлтийн дагуу цэцэрлэгийн 32 багш ажилчид, 208 хүүхэд, эцэг эх асран хамгаалагч нарын дунд дараах үйл ажиллагааг зохион явууллаа.

1. “Аюултай хог хаягдал” нээлттэй сургалт үйл ажиллагаа, жүжигчилсэн тоглолт
2. “Эх дэлхийгээ хайрлая” цахим контент
3. “Аюултай хог хаягдлыг алгас” аян



Цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 40 гаруй хүүхдүүдэд “АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ” түүний хор нөлөөг хүүхдүүдэд олгох зорилго бүхий жүжигчилсэн тоглолтыг 6 бүлгийн багш хамтран зохион явуулсан.



Аюултай хог хаягдлын хор уршгийн талаарх 2 цахим контентийг хүүхдүүд, эцэг эх асран хамгаалагч нарт бэлтгэн Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын тэргүүний 1-р цэцэрлэг цахим хаягт байршуулан ажилласан.

Цэцэрлэгийн 32 багш ажилтан, 208 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарын дунд гэртээ ашиглахгүй болсон хуруу зай, эм зэргийг зориулалтын саванд авчирч хийх аян өрнүүлсэн. Аяны хүрээнд 100 гаруй хуруу зай, 70 гаруй төрлийн хугацаа нь дууссан эм цугларсан байна.



1 дүгээр сургууль: Аюултай хог хаягдал гэж юу вэ? Түүнийг хэрхэн ангилан ялгах, дахин боловсруулах, устгах нь сэдвээр сургалт зохион байгуулсан.

Тус сургуулийн 6-12 ангийн 29 бүлгийн 1032 сурагчдад эко клубын багш Б.Мандах сургагч хүүхдүүдээр дамжуулан сургалтыг зохион байгуулсан ба сурагчид аюултай хог хаягдлын тухай мэдлэг, хандлагыг эзэмшсэн.

12700 гишүүнтэй сургуулийн нээлттэй группт байх багш, ажилчид, сурагчид тэдний



эцэг эхчүүдэд энэ тухай ойлголтыг цахимаар дамжуулсан ба одоогоор 200 гаран хүн үзэж, 12 группт шэйрлэгдэж нөлөөллийн ажил хийгдсэн байна

6-12 ангийн бүх бүлгийн дарга нараар дамжуулан хаягдал зай батарей цуглуулах ажлыг зохион байгуулсан ба түүнийг ил задгай хаяхгүй байх нь байгаль экологи, ирээдүй хойч үед маань чухал нөлөөтэй талаарх мэдээллийг өгч ажилласан. Аюултай хог хаягдлыг МУ-д устгах, дахин боловсруулах үйлдвэр байдаггүй, хүмүүсийн дунд энэ тухай мэдлэг хомс зэргээс шалтгаалан ил задгай ахуйн хогтой хаях нь бидний эрүүл мэндэд мөргөөр нөлөөлдөг тул тагтай саванд цуглуулан зохих газар нь тушаах нь зөв гэдэг ойлголтыг түгээн дэлгэрүүлсэн болно.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Айл өрх, ААНБ-ын ахуйн хэрэглээний хог хаягдлыг 2-р сард хуваарийн дагуу тогтмол тээвэрлэж хогийн нэгдсэн цэгт устгаж булшилсан.



Нийтийн эзэмшлийн 12 авто зогсоол **47500м²** явган хүний зам, **246000м²** авто зам, **12000м²** үерийн даланг хуваарийн дагуу тогтмол цэвэрлэж нийт тонн орчим хогийг хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан.



Нийтийн эзэмшлийн авто болон явган замын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж 3-4, 4-5 тойрог холбоос замын мөстлөг зохиж арилгах ажил хийгдсэн.

Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, Хувийн эмнэлгүүдийн аюултай хогийг гэрээнд заасан хуваарийн дагуу сар бүрийн 7 хонгийн 6 өдөр авч энэ сард дунджаар нийт 2160кг 900г аюултай хогийг ачиж тээвэрлэж устгаад байна.






Хогийн цэгийн түрэлт сар бүр тогтмол хийгдэж байна.



Засвар үйлчилгээ жижиг ковш мотор солих ажил хийгдсэн.





Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан компанийн засаглалын 36 цагийн сургалтад манай байгууллагаас ньбо Б.Урантүлхүүр хамрагдсан.



Харилцаа хандлага сайжруулах, түүний сайн чанарын талаарх сургалтад байгууллага хамт олноороо 100% ирцтэй хамрагдсан.





Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй холбоотой Гэр бүл хүүхэд, залуучуудын газар, Боловсролын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газраас хамтран “АНЗААР” арга хэмжээнд байгууллага хамт олноороо хамрагдсан.




Цагаан сар цаг үетэй холбогдуулан гэрэлтүүлгийн асалт, унтралтад авто замын гэртүүлэг болон гэр хороололын цамхагт гэрэлтүүлгийн асалт, унтралтын цагийн тохируулга хийж, гэрлийн шон засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.





Автозамын баруун 4-н замын гэрлэн дохионы гэрлийг засварлаж гүйцэтгэлээ.



Орон сууцны гадна гэрэлтүүлгийн засварын ажлын хүрээнд:

Орон сууцны гадна гэрэлтүүлгийн засварын ажлыг гүйцэтгэж, Ногоон хотхон-2ш прожектор, Даймонд хотхонд 2ш, Одкон хотхонд 2ш, 60 айлд 3ш, Жаргалан хотхоны 48 айлын орон сууцанд 3ш, нийт 12ш прожектор гэрэлтүүлэг шинэчлэн хийж, асахгүй болсон 3 хотхоны гэрэлтүүлгийг шинэчлэн засварлаж, гэрэлтүүлгийн асалтыг нэмэгдүүлж ажиллалаа.






Орон сууцны усны хаялага, агааржуулалтын хоолой бөглөрч айл өрхийн шугамаар өмхий үнэр ханхалж байгаа үзэгдлийг арилгах үүнднээс агааржуулалтыг хоолойн бөглөрлийг игаргаж ажиллалаа. 36 айлын орон сууц, Дөрвөлж 12 айлын орон сууцны 2 орцны агааржуулалтын цас мөс бөглөрлө арилсан.



Орцны гэрэлтүүлгийн засварын ажлыг гүйцэтгэж, асахгүй байгаа гэрэлтүүлгүүдийг засварлаж, шинэчлэн сольж, асаах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Мандал хотхонд 2ш гэрэл, Залуус хотхоны 5-р байрны 3,4 давхарт- 2ш, 48 айл 4-р орц 1ш, Ногоон хотхон 104-р байр 3 давхарт 1ш эвдэрсэн гэрлийг засварлаж, нийт 4 байрны 6 орцонд 6ш мэдрэгчтэй гэрлийг сольж, Баазын 8- айлд -1ш гэрэл шинээр утас татаж сурилуулан гэрэлтүүлгийн асалтыг нэмэгдүүлж ажиллалаа. Нийт 6ш гэрлийн засварт 150.000 төгрөг зарцуулагдлаа.





Самбарын засварын ажлын хүрээнд:

Баруун төв зам дагуу байрлах гүүрэн самбарыг бүрэн засварлаж, төмөрлөх хавтан хадаж төмөрлөх шинэчилж суурилуулах ажлыг хийж, самбарыг ашиглаланд орууллаа. Самбарын засвар 2462.0 төгрөгний өртөгтэй засварлагдлаа.




Орон сууцны засварын ажлын хүрээнд: Цайрт хотхоны 3-р байрны 3-р орцны айл өрхийн цэвэр усны шугам хөлдөж хагарсан эвдрэлийг засварлаж, нийт 65,0 төгрөгний өртөгтэй зарцуулсан.



Дөрвөлж хотхоны 1-р байрны айл, өрхийн цэвэр усны шугам хөлдөж, орцны доод подвалын ханыг нурааж шугам хоолойг засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ. Засварын материалын зардалд 80,0 төгрөг зарцуулсан.



Орон сууцны цонх шиллэх, ажил хийгдэж, 2 байрны 2 цонхыг шиллэж дулаалах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Орцны хаалга засварлах ажил хийгдэж, Мандал хотхонд 5ш хаалга, Жаргалан хотхонд-2ш хаалга, Цэлмэг хотхонд 2ш хаалга, Бааз -8 айл хаалга, Ягаан 24-2 хаалга, Автотээвэр, Ногоон хотхонд 3ш хаалга нийт 6 хотхоны хаагдахгүй болсон, эвдэрсэн 12-н

хаалга засварлаж, 5 хаалганд пүрш, татуурга хийж, 2 хаалганд хөөс шахаж бэхлэх зэрэг ажлыг хийж, бүрэн бүтэн байлгах байдлыг хангаж ажиллалаа.




Гадна талбайн цас цэвэрлэх ажил: Орон сууц, хотхоны гадна талбайн цас цэвэрлэх ажлыг ээлж дараатай хийж гүйцэтгэж, Даймонд хотхон, Дөрвөлж хотхон, Залуус хотхон, Цэлмэг хотхон, Саруул хотхон, нийт 5 хотхоны гадна цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.




Мандал хотхоны повдалын лаг шавар тогтсон усыг цэвэрлэж асгах, өмхий үнэрийг арилгаж, ариутгах ажил хийгдлээ.




Орон сууцны бохирын шугам задарч засварын ажил хийгдэж, Мандал хотхон, Дөрвөлж хотхон 2 байрны орц, подвалын усыг шавхаж зөөх ажил хийгдлээ.






Цайртын орчны хөлдөлтийн мөсийг цэвэрлэж зөөвөрлөж асгах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Баруун-Урт хотын төвд орж ирсэн малыг гаргах, хашиж саатуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. 2023 оны 2 дугаар сарын 20-26-ны өдрүүдэд хуваарийн дагуу хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, хотын төвд бэлчиж яваа малыг хөөж туун гаргах, 2 айлын 13 үхэр хашиж, нийт 78 малыг хөөж, 6 өдрийн турш хотын төвөөс мал гаргаж ажлыг хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд машин, техникийн зохицуулалтыг хийж, 6 өдөрт 60л бензин тос, 153,900 төгрөгний шатахуун зарцуулагдлаа.





Орон сууцны цэвэрлэгээний ажилчдын ажлын хэрэгцээнд зориулж цэвэрлэгээний материалыг тараан олгож, орон сууцны цэвэрлэгээнд хяналт тавин ажиллаж байна.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал